

**МӨРДӨН БАЙЦААЛТЫН АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН  
МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙГ  
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ**



**Ж.Одончимэг**

Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн II хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад, ХСИС-ийн магистрант

Mail: [odnoo2015@yahoo.com](mailto:odnoo2015@yahoo.com)

**Товч агуулга:** Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг дэлхийн нийтийн жишиг хандлагад хүргэхийн тулд Монгол Улс түүнийг зохицуулах эрх зүйн шинэтгэлийг эрчимтэй хэрэгжүүлж байна. Үүнтэй холбогдуулж мөрдөн байцаалтын ажиллагааг ямарваа нэг алдаа дутагдалгүй, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй, үүрэгт ажлаа хуулийн хүрээнд бүрэн дүүрэн биелүүлэх, орчин үеийн техник технологийн хөгжлөөс хоцролгүй хөл нийлүүлэн ажиллах нь цагдаагийн байгууллагын анхаарах асуудлын нэг болж энэ талаар шинэчлэл хийгдсээр байна. Сүүлийн жилүүдэд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд урьдаас төлөвлөсөн зохион байгуулалтын шинжтэй болж тэдний үйлдсэн эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэхэд багагүй саад бэрхшээл учирч байна.

**Түлхүүр үг:** Мөрдөн байцаалтын ажиллагаа, зохион байгуулалт, мэргэжлийн удирдлага, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, эрүүгийн хэрэг

**Оршил**

Мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах” тухай ойлголтын талаар авч үзэхийн өмнө хэл бичгийн найруулга зүйн бүтцээс нь авч үзвэл “мөрдөн байцаалтын ажиллагаа”, “зохион байгуулалт”, “мэргэжлийн удирдлага” гэсэн тус тусдаа утга агуулгыг илэрхийлсэн, бие даасан хоршоо үгнүүдийн нийлбэрээс бүрдэж байгааг харагдуулж байна, хууль зүйн ойлголт талаасаа яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах замаар хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж гэмт хэрэг түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг хэрэгжүүлэгч субъект түүний хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэх үйл явц, нөгөө талаас түүний үйл ажиллагааг дэмжих, удирдан чиглүүлэх, үйл ажиллагаанд нь ямар нэгэн зөрчил, дутагдал гаргахгүй байхад чиглэсэн бодит арга хэмжээ авах зорилго чиглэл бүхий агуулгатай олон талт үйл ажиллагааны нэгдэл гэж үзэж болохоор байна.

Удирдахуйн ухаанд зохион байгуулалтын удирдлага, мэргэжлийн удирдлагыг дараах байдлаар тодорхойлсон.

Зохион байгуулалтын удирдлагаар хангах гэдэг нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хүн, материал, мэдээлэл, санхүүгийн бүх төрлийн нөөцийг оновчтойгоор нэгтгэн зангидах үйл явц юм<sup>1</sup>.

Мэргэжлийн удирдлагаар хангах гэдэг нь аливаа үйл ажиллагааг өмнөө тавьсан зорилго, зорилтдоо нийцүүлэн явуулахад мэргэжлийн талаас нь онолын болоод арга зүйн дэмжлэг үзүүлэх, зорилго, зорилтоосоо хазайсан буруу үйл ажиллагааг зогсоох, түүнийг гарахаас урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн талаас нь зөвлөх, чиглүүлэх чиг үүрэг бүхий удирдлагын үйл ажиллагааны нэг хэлбэр юм гэж тодорхойлсон байна<sup>2</sup>.

Мөрдөн байцаалтын ажиллагаатай холбоотой прокурорын байгууллагаас 2016 онд орон нутагт 45 хувь буюу 59, нийслэлд 55 хувь буюу 73, нийт 132 прокурорын шаардлага, орон нутагт 22 хувь буюу 15, нийслэлд 78 хувь буюу 53, нийт 68 хариуцлага тооцуулах тухай албан бичиг ирүүлж давхардсан тоогоор 599 хуулийн зүйл заалт зөрчсөн байна. Давхардсан тоогоор 723 зөрчилд 199 мөрдөн байцаагч нэр дурдагдсан нь улсын хэмжээнд ажиллаж байгаа 494 мөрдөн байцаагчийн 40.2 хувийг эзэлж, орон нутагт 56 алба хаагчийн цалинг 1-2 сар хүртэл хугацаагаар 5-20 хувиар хасч, 20 алба хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан, нийслэлд 87 алба хаагчийн цалинг 1-3 сар хүртэлх хугацаагаар 5-20 хувиар хасч, 10 алба хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан, 37 алба хаагчийн гаргасан зөрчил тогтоогдоогүй байна<sup>3</sup>.

Нийт шаардлагын 58.3 хувь буюу 77 шаардлагад дурдагдсан 284 зөрчил нь мөрдөн байцаагч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах, дотооддоо тавих хяналтаа сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ аваагүйгээс гарсан гэж үзэн Прокурорын байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193 дугаар зүйлийн 193.1.23 дахь хэсэгт заасныг удирдлага болгон прокурорын шаардлага бичжээ.

Шаардлагад дурдагдсан зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байгаа (давхардсан тоогоор) 723 зөрчлийн 80 хүртэл хувийг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28 (Мөрдөн байцаагчийн эрх үүрэг), 80 (Хэргийн талаар нотолбол зохих асуудлууд), 182 (Мөрдөн байцаалт явуулах хугацаа), 194 (Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорын шийдвэрийг заавал биелүүлэх) дугаар зүйл хэсэгт заасан мөрдөн байцаалтын ажиллагааг зөрчиж байна. Зөрчлүүдийн талаар товч дурдвал:

ЭБШХуулийн 80 дугаар зүйл: Хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг бүрэн тогтоодоггүй, гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэргийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр, холбогдогч нарын хувийн байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл зэргийг нарийн шалгаж тогтоодоггүй, дутуу хийдэг.

ЭБШХуулийн 28 дугаар зүйл: Мөрдөн байцаагчийн эрх, үүргийг тодорхой заасан боловч эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргахдаа хугацаа алддаг,

<sup>1</sup> Цэнд.Н нар “Менежмент” 2013 он Т.157

<sup>2</sup> Цэнд.Н нар “Менежмент” 2013 он Т.138

<sup>3</sup> Мөрдөн байцаах газрын 2016 оны тайлан

гомдол, мэдээллийг бүрэн дүүрэн шалгадаггүй, эрүүгийн хэрэгт дутуу ажиллагаа хийж үндэслэлгүй түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох санал гаргаж прокурорт шилжүүлдэг, хэргийн газрын үзлэгийг чанаргүй явуулдаг, үзлэг тэмдэглэлийг дутуу бичдэг, шинжээч томилох тогтоол, дүгнэлтийг оролцогч нарт танилцуулдаггүй, цаг хугацаа алдаж хохирогч, сэжигтнээр тооцож байцаалт авдаг, хэргийн нотлох баримт цуглуулах ажиллагааг хууль зөрчиж хийдэг, эд хөрөнгө битүүмжлэх, хамгаалах ажиллагаа хийдэггүй, хуулийн заалтыг ягштал баримталж хэргийг яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой шалгаж гэмт хэрэг, үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна гэсэн хуулийн заалтыг хангалтгүй биелүүлдэг, мөрдөн байцаагч өөрийн санаачлагаар дээрх ажиллагаануудыг хийдэггүй. Мөн прокуророос өгсөн даалгаврыг заавал биелүүлэх үүрэгтэй боловч ажиллагаанд нь болон нэмэлт мөрдөн байцаалтад буцсан, хугацаа сунгасан эрүүгийн хэрэгт бичсэн прокурорын даалгаврын заалтуудыг бүрэн ханган биелүүлдэггүй, эсвэл дутуу, огт биелүүлдэггүй зөрчил ихээр гарсан.

ЭБШХуулийн 182 дугаар зүйл: Мөрдөн байцаалт явуулах хугацаа тодорхой заасан байдаг боловч мөрдөн байцаагч нар хэргийн хугацаа хэтрүүлж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, хэрэгт ажиллагаа хийхгүй хугацаа хэтрүүлж дарагдуулах зөрчил ихээр гарч байна. Хэрэгт хугацаа авсан өдрөөс дуусах өдөр хүртэл ямар ч ажиллагаа огт хийхгүй дараагийн хугацаа авдаг, дутуу хийсэн, хэрэгт ач холбогдолтой ажиллагаа хийгээгүй, хэргийг прокурорт шилжүүлэхдээ 72 цаг хэтрүүлэн өгдөг, 72 цагийг хэргийн хугацаа мэтээр ойлгож мөрдөн байцаалтын ажиллагаа явуулдаг зөрчил их байна.

ЭБШХуулийн 194 дүгээр зүйл: Мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорын шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй боловч мөрдөн байцаагч нар нь хяналтын прокурорын амаар болон бичгээр өгсөн шийдвэр, даалгаврын заалтууд биелүүлдэггүй, дутуу биелүүлдэг зөрчил ихээр гарч, прокурорын шаардлагад дурдагдаж байна. Прокурорын даалгаварт заагдсан ажиллагааг хийдэггүй зөрчил нь прокурорын шаардлагын дийлэнх хувьд бичигдсэн байна.

Дээрх шаардлагуудад мөрдөн байцаалтын ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, гарсан зөрчлийг засуулах, давтан гаргуулах байх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах талаар дурдагдсан боловч байцаан шийтгэх ажиллагааны зөрчил, прокурорын шаардлагын тоо буурахгүй байгаа нь мөрдөн байцаах албаны дарга мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллаагүйтэй холбоотой гэж үзэж байна. Прокурорын шаардлагын мөрөөр нэг ч мөрдөн байцаах албан дарга сахилгын арга хэмжээ авагдаагүй гэсэн тоо баримт гарч байна.

Иймд мөрдөн байцаалтын ажиллагааг удирдлагын зүгээс зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангахад чиглэсэн асуудлыг судалж, гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд бодит байдлаар зохион байгуулалт, мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг орчин үеийн менежментийн удирдлагын онолтой хослуулан хэрэгжүүлж, улмаар эрх зүйн болон зохион байгуулалтын орчин нөхцлийг сайжруулан шинэ шатанд гаргаснаар дээрхи зөрчил, дутагдал гаргахгүй байх нөхцөл боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

## Үндсэн хэсэг

Мөрдөн байцаалтын ажиллагаанд өнөөдрийг хүртэл оршиж байгаа зөрчил, дутагдал нь:

- Мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаах тасгийн ажлын дадлага, туршлага, мэдлэг, чадвар сул;
- Мөрдөн байцаах албаны даргын дэмжлэг туслалцаа бага, оновчтой бус,
- Мөрдөн байцаах нэгж, албадын уялдаа холбоо, бүтэц зохион байгуулалт боловсронгуй бус, байнга өөрчлөгдөж, шинэчлэгдэж байгаа нь тогтвортой бус байдлыг бий болгож байгаа;
- Мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаах тасгийн ажлын гүйцэтгэлийн үнэлэмж тодорхой бус;
- Үйл ажиллагааны шуурхай, соёлч байдал дутмаг зэрэг гадаад, дотоод орчны олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Иймд мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг сайжруулах, түүнийг шинэ шатанд гаргах, боловсронгуй болгоход чиглэсэн дараах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

*1. Мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаах тасгийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлэмж өнөөгийн бодит байдалтай нийцэхгүй хэт их статистик, тоон үзүүлэлтээр дүгнэж байгааг өөрчлөн мөрдөн байцаалтын ажиллагааны чанар, гүйцэтгэлээр нь тооцдог болгох.*

Мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагчийн сарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх гол үзүүлэлт нь түүний сард шийдвэрлэсэн байх хэргийн тоо<sup>4</sup> бөгөөд ийм нөхцөлд алба хаагчид зөвхөн сард шийдвэрлэх ёстой хэргийн тооны араас хөөцөлдөж харин мөрдөн байцаалтын ажлын чанар дараагийн асуудал мэт ойлгох ойлголт нийтлэг байгаа нь ихээхэн учир дутагдалтай байна. Мөрдөн байцаах нэгж, тасаг, хэлтсийн дарга, удирдлагын зүгээс ч тавьж байгаа шаардлага нь мөрдөн байцаалтын хугацаа сунгагдан шалгагдаж байгаа хэргийг л хурдан шуурхай дуусгаж шийдвэрлэн прокурорт шилжүүлэх нь гол болохоос бус мөрдөн байцаагчийн нь мэдлэг, чадвар дутмаг байдлаас хууль зөрчих, хэрэгт мөрдөн байцаалт явуулах хугацааг үндэслэлгүйгээр сунгаж, хэт удаан хугацаагаар хэрэгт мөрдөн байцаалт явуулах, яллагдагчийг хорьж мөрдөх хугацааг олон сараар үндэслэлгүй сунгах зэрэгт шүүмжлэлтэй хандаж түүний шалтгаан нөхцлийг судлах, гаргуулахгүй байхад чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байна.

Эрүүгийн хэрэгт хийсэн түүвэр судалгаанаас харахад яллагдагчийг нэг сар хорьж мөрдөх хугацаанд түүнийг 2 удаа, гэрч, хохирогчийг тус бүр 1 удаа байцаасан, учирсан хохирлын үнэлгээ хийсэн гэхээс өөр ямар ч ажиллагаа явуулаагүй мөрдөн байцаалтын хэрэг хүртэл байгаа нь мөрдөн байцаах тасгийн даргын зүгээс тавих хяналт сул, мөрдөн байцаагч нэг бүрийн гар дээр шалгагдаж байгаа хэрэг материалтай биечлэн танилцаж зааварчилгаа, зөвлөгөө өгч мэргэжлийн удирдлагаар жигд хангаж ажиллахгүй байгаагийн нэг хэлбэр юм.

Нөгөө талаар мөрдөн байцаах тасгийн ажлыг үнэлэх үзүүлэлт нь зөвхөн шалгасан хэрэг, материалын тоон үзүүлэлт, статистик тоо баримтууд байхаас бус

---

<sup>4</sup> дүүргийн 1 мөрдөн байцаагч сард 4 эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгаж шийдвэрлэсэн байх ёстой.

мөрдөн байцаалтын ажиллагааны явцад зөрчил, дутагдал гарсан эсэх, түүнийг хэрхэн шалгаж шийдвэрлэсэн, мөрдөн байцаах тасгийн даргын зүгээс мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан эсэх тухай үзүүлэлт огт байхгүй байна. Иймд нэгдсэн дүн мэдээнд мөрдөн байцаах албаны дарга нарын мөрдөн байцаагч нарын шалгаж буй хэрэг бүрт хүрч ажиллаж, зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан талаар шинэ үзүүлэлтийг тусгаж өгөх нь мөрдөн байцаах ажиллагааны чанарт эерэг үр дүн гарна гэж үзсэн.

*2. Шинэчлэл нэрийн дор байнга бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж байгаа нь мөрдөн байцаалтын ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлж мөрдөн байцаагчийн тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзмэл багасч түүгээр ч барахгүй мөрдөн байцаах нэгж, тасаг, хэлтсийн удирдлага байнга солигдож байгааг өөрчлөн мөрдөн байцаах нэгж, тасаг, хэлтсийн даргын албан тушаалд мэргэжлийн, дадлага, туршлагатай алба хаагчийг сонгон шалгаруулалтаар дэвшүүлэн томилох зарчмыг баримтлан ажиллах.*

Мөрдөн байцаах алба 1946 онд<sup>5</sup> анх байгуулагдаж Монгол Улсын хэмжээнд мөрдөн байцаах үйл ажиллагааны нэгдсэн удирдлагыг төвлөрүүлэн хэрэгжүүлж байсан Улсын мөрдөн байцаах газрыг татан буулгаж түүний оронд Эрүүгийн цагдаагийн газар, Мөрдөн байцаах газрыг нэгтгэсэн Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрыг байгуулсан нь дээрхи тусгай чиг үүрэгтэй газруудын эрх хэмжээг багасгаж улмаар гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны чанарт сөрөг нөлөө үзүүлсэн шийдвэр болсон гэж үзэж байна. Мөн ЦЕГ-ын бүтцэд Гэмт хэрэгтэй тэмцэх албыг байгуулсан орон тооны давхардал, удирдлагын бүтцийн оновчгүй хуваарилалт болсон байсан. Иймд мөрдөн байцаах албаны хамгийн оновчтой, сонгомол бүтцийг байгуулж ажиллах нь зүйтэй бөгөөд үүний хамгийн зөв хувилбар нь мөрдөн байцаах албадыг нэгтгэн түүнийг мэргэжлийн удирдлагаар хангаж дагнан ажилладаг бие даасан албыг байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

*3. Мөрдөн байцаах албаны алба хаагчдыг сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэхэд чиглэсэн сургалт нь нэгдсэн бодлого, төлөвлөлт, тусгайлан боловсруулсан хөтөлбөргүйгээр явж ирсэн нь тэдгээрийн мэдлэг, боловсрол, ур чадварт зохих хэмжээгээр нөлөөлж энэ нь мөрдөн байцаалтын ажиллагаанд сөрөг үр дагаварыг бий болгосон гэж үзэж байгаа тул сургалтад онцгой анхаарах.*

Мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаах тасгийн даргыг сургах сургалтын үйл ажиллагаа нь дараах үндсэн хэлбэрүүдээр явагдах ба эдгээр нь хоорондоо нягт уялдаа холбоотой, системтэй явагдах ёстой гэж үзэж байна. Үүнд:

- шинээр томилогдсон мөрдөн байцаагчийг чиглүүлэх сургалт (*мөрдөн байцаагчаар томилогдсон тушаал гарснаас хойш 1-6 сарын хугацаанд үргэлжлэн явагдах*);
- мөрдөн байцаагчийн давтан сургалт (*мөрдөн байцаагч жилд нэг удаа заавал хамрагдаж байх*);
- мэргэжил дээшлүүлэх сургалт (*мөрдөн байцаагч 2 жил тутамд хамрагдаж байх*);

---

<sup>5</sup> Давааням.А Мөрдөн байцаах байгууллагын бүтэц, чиг үүрэг УБ., 2006 168 хуудас.

- мэргэшүүлэх сургалт (3 хүртэл жил ажилласан мөрдөн байцаагчийг тодорхой төрлийн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах чиглэлээр мэргэжүүлэх);
- гадаад сургалт (гадны өндөр хөгжилтэй оронд сургалтад хамруулах);
- төлөвлөгөөт сургалт (сургалтыг улирал, хагас жил, жилээр, тодорхой бүлэг, сэдвийн хүрээнд төлөвлөн явуулах);
- зайн сургалт (онлайн сургалтыг бүх нэгж, тасгийн дунд явуулах);
- хамтарсан сургалт (тодорхой нэгж, албад хамтарч мөн гадны байгууллага түүн дотроо Хүний Эрхийн Үндэсний Комисс, хүний эрхийн бусад байгууллагуудтай хамтран явуулж байх);
- туршлага солилцох сургалт (харилцан бие биенээсээ суралцах хэлбэрээр нэгдсэн байдлаар зохион байгуулах сургалт);
- бүсчилсэн сургалт (төв, зүүн, баруун, хойд, урд гэх мэт хуваарилалтаар сургалтыг 2 жилд 1 удаа явуулж байх);
- нэгдсэн сургалт (төвийн бүсийн нэгдсэн сургалт, орон нутгын нэгдсэн сургалт гэх мэт хуваарилалтаар явуулж байх);
- мөрдөн байцаагчийн улсын зөвлөгөөн (5 жилд 1 удаа явуулж байх) гэх мэт олон хэлбэрээр явагдаж байж сая мөрдөн байцаагчийн мэдлэг, ур чадвар бодитоор дээшилж ажил гүйцэтгэх чадварт чанарын эрс ахиц гарна гэж үзэж байна.

*4. Мөрдөн байцаах албаны одоогийн бүтэц, тогтолцоог өөрчлөн цагдаагийн байгууллагын бүтцээс гарган бие даан хөгжүүлэх.*

Мөрдөн байцаах алба нь хуулиар цагдаагийн байгууллагын бүтцийн нэг нэгжид багтаж байснаараа өөрийн үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, мөрдөх чиг үүргээс гадна цагдаагийн байгууллагын алба хаагчийн хувьд нийтлэг үүргийн дагуу нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг давхар хэрэгжүүлж байгаа нь мөрдөн байцаагч үндсэн үүрэгт ажлаасаа гадна олон чиг үүрэг бүхий ажилд хутгалдан орж байгаа нь мөрдөн байцаалтын ажиллагааны шуурхай, тасралтгүй явагдах зарчимд болон түүний чанарт ихээхэн сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тухайлбал, нийтийн эргүүл нэрээр сард 2-3 удаа хэв журмын эргүүлд гарах, Нийтийн баяр ёслолын амралт, нийгмийн хэв журам хүндэрсэн нөхцөл, нийтийг хамарсан арга хэмжээ гэх мэт олон үйл ажиллагаанд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин олон цаг, хоногоор үүрэг гүйцэтгэж байгаа мөрдөн байцаагч ямар цаг хугацаанд нь өөрийн үндсэн ажлаа хийж гүйцэтгэх нь үнэхээр тодорхой бус юм. Үүний хажуугаар гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл тасралтгүй ирж түүнд чиглэсэн ажиллагааг шуурхай авч хэрэгжүүлэхэд мөрдөн байцаах тасгийн мөрдөн байцаагчийн орон тоо үүсэн гарч байгаа ажлын ачаалалд хүрэлцэхгүй байна. Үүний тулд мөрдөн байцаах албыг цагдаагийн байгууллагын бүтцээс гаргаж бие даасан статус бүхий байгууллага болгож хөгжүүлэх нь зүйтэй.

*5. Мөрдөн байцаалтын ажиллагааны явцал мөрдөн байцаагч нэг бүрийн ажиллах нөхцөл боломжийг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал бөгөөд үүнийг тодорхой хөрөнгө, төсөв гаргаж шуурхай шийдвэрлэх*

Мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын удирдлагаар хангахад чиглэсэн гол асуудлын нэг бол мөрдөн байцаагчийн ажиллах орчин нөхцлийг

сайжруулах улмаар олон улсын жишиг стандартад ажлын байрны нөхцлийг хүргэх явдал юм.

Судалгааны ажлыг явцад нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн гуравдугаар хэлтсийн мөрдөн байцаах тасгийн үйл ажиллагаатай танилцсан бөгөөд уг хэлтсийн байр нь Сонгинохайрхан дүүргийн прокурорын газартай нэг байранд байдаг, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид нь алба, албаараа нэг том зааланд сууж үйл ажиллагаа явуулж байгаа нь үнэхээр нэгэн зэрэг, нэг цаг хугацаанд мөрдөн байцаалтын өөр өөр ажиллагааг мөрдөн байцаагч нар явуулж байгаа нь ажлын чанарт бодитоор сөрөг нөлөө үзүүлж байна.

Дээрх орчин нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэж байгаа мөрдөн байцаагчаас мөрдөн байцаалтын ажлын чанар, үр дүн шаардах нь нэг талаасаа мөн л учир дутагдалтай бөгөөд нөгөө талаасаа ажлын байранд тавигдах наад захын шаардлагыг хангахгүй орчинд ажлаа гүйцэтгэж байгаа нь орчин цагийн мөрдөн байцаагчаас хол хоцрогдсон.

Олноороо нэг тасалгаанд сууж албан үүргээ гүйцэтгэхэд дараах сөрөг үр дагаврууд байнга ажлын чанарт нөлөөлж байдаг болох нь судалгаагаар нотлогдсон байна. Үүнд:

➤ Олон хүний амьсгалаар өрөө тасалгааны агааржуулалт дутагдаж удаан хугацаанд ажиллахад эрүүл ахуйн орчин талаасаа шаардлага хангахгүй байх нөхцөл бүрдэнэ;

➤ Бүх төрлийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа нэг цаг хугацаанд, нэгэн зэрэг явагдаж байгаа нь бие биенээсээ хамааралгүй явагдах тодорхой ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлнэ. Өөрөөр хэлбэл хөндлөнгийн нөлөөлөл, дуу чимээ ихтэй орчинд байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид бухимдах, сэтгэл санаа тогтворгүй байх, үл итгэлцэх орчин үүсэх улмаар мөрдөн байцаагчид хэргийн талаар бодит үнэнийг мэдүүлэх хүсэл сонирхол буурах сөрөг нөлөөлөлтэй.

*6. Мөрдөн байцаах албаны дарга нь цагийн менежментийг зөв хэрэгжүүлж ажиллан мөрдөн байцаагчийн ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.*

Өнөөдрийн байдлаар мөрдөн байцаагчийн ажлын өндөр бүтээмжтэй цагуудыг өдөр бүр шат шатны хурал дамжин сууж өнгөрөөж байна.

Судалгааны ажлын хүрээнд мөрдөн байцаагчийн нэг өдрийн ажлын зураглалыг дараах байдлаар тодорхойлж гаргасан. Үүнд:

- Хэлтсийн өглөөний рапортанд суух 08:30-10:20

- Мөрдөн байцаах албаны даргын өрөөнд хуралд суух 10:20-10:55 зэрэг хэлбэрээр үдээс өмнөх ажлын цагийн талаас илүү хувийг хурал, цугларалтад зарцуулж байгаа нь иргэдийг чигрэгдүүлэх, бухимдах нөхцлийг удирдлагын үйл ажиллагааны оновчгүй хэрэгжилтийн үр дүнд бий болгож байна гэж үзэхээс өөр аргагүй юм.

Ер нь мөрдөн байцаах албаны дарга мөрдөн байцаагч нарын үндсэн ажлыг өглөө эрт эхлүүлэх, хийж байгаа ажилд нь хөндлөнгийн зүгээс саад учруулахгүйгээр цагийн оновчтой хувилбарыг тооцож ажиллах нь илүү үр дүнтэй. Иймд мөрдөн байцаах тасгийн даргын анхаарах хамгийн чухал асуудал бол мөрдөн байцаагч үндсэн үүрэгт ажлаа хийж гүйцэтгэх цагаас аль болох хурал, цуглаан нэрээр авахгүй, түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх нөхцлийг бүрдүүлж өөрийн

удирдлага, зохион байгуулалтын эрх хэмжээгээ хэрэгжүүлэх нь чухал. Энэ нь мэдээж хэдийгээр жижиг асуудал мэт санагдавч үнэн хэрэгтээ удирдах ажилтны менежмент ур чадвартай холбоотой бөгөөд албаны дарга үүнд цуцалтгүй суралцах нь чухал юм.

### **Дүгнэлт**

1.“Мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах гэдэг нь мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогчдын хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн үйлдлийг таслан зогсоох, уг ажиллагааны явцад хууль ёсыг сахиулах, хууль ёс зөрчсөн үйлдлийг зогсоох, түүнийг залруулах, мөрдөн байцаалтын ажиллагаанд гаргасан гомдол, мэдээллийг шалгах, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, шийдвэрлэх, мөрдөн байцаагч нарыг ажиллах нөхцөл бололцоогоор хангахад чиглэсэн мэдээлэл, санхүүгийн гэх мэт бүх төрлийн нөөцийг оновчтойгоор нэгтгэн зангидахад чиглэсэн чиг үүрэг бүхий удирдлагын үйл ажиллагааны нэг хэлбэр” гэж тодорхойлж байна.

2. Мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагчийн сарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх гол үзүүлэлт нь түүний сард шийдвэрлэсэн байх хэргийн тоо<sup>6</sup> бөгөөд ийм нөхцөлд алба хаагчид зөвхөн сард шийдвэрлэх ёстой хэргийн тооны араас хөөцөлдөж харин мөрдөн байцаалтын ажлын чанар дараагийн асуудал мэт ойлгох ойлголт нийтлэг байгаа нь ихээхэн учир дутагдалтай байна. Мөрдөн байцаах нэгж, тасаг, хэлтсийн дарга, удирдлагын зүгээс ч тавьж байгаа шаардлага нь мөрдөн байцаалтын хугацаа сунгагдан шалгагдаж байгаа хэргийг л хурдан шуурхай дуусгаж шийдвэрлэн прокурорт шилжүүлэх нь гол болохоос бус мөрдөн байцаагчийн нь мэдлэг, чадвар дутмаг байдлаас хууль зөрчих, хэрэгт мөрдөн байцаалт явуулах хугацааг үндэслэлгүйгээр сунгах зэрэгт шүүмжлэлтэй хандаж түүний шалтгаан нөхцлийг судлах, гаргуулахгүй байхад чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байна.

3.Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад байцаан шийтгэх ажиллагааны зөрчил ихээр гарч байгаа нь мөрдөн байцаах албаны даргын удирдлага, зохион байгуулалттай салшгүй холбоотой байна.

### **Санал**

1. Мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг сайжруулахад чиглэсэн менежментийн удирдлагын тодорхой арга хэмжээнүүдийг шат дараалсан хэлбэрээр, оновчтой хэрэгжүүлэх.

2. Мөрдөн байцаах албаны даргын удирдан манлайлах ур чадварыг байнга дээшлүүлэх, тэдэнд зориулсан сургалтыг тогтмол явуулах.

3. Мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг орчин үеийн менежментийн удирдлагын арга барилтай хослуулан хэрэгжүүлэх зэрэг шаардлага байгааг анхааран үзэх нь чухал байна.

### **Ном зүй**

1. Эрүүгийн байцаан шийтгэх хууль УБ., 2002 он

---

<sup>6</sup> дүүргийн 1 мөрдөн байцаагч сард 4 эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгаж шийдвэрлэсэн байх ёстой.



2. Давааням.А “Мөрдөн байцаах байгууллагын бүтэц, чиг үүрэг” УБ., 2006
3. Цэнд.Н нар “Менежмент” 2013 он
4. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагааг удирдлагаар хангах тухай ЦЕГ-ын даргын 2003 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 512 тоот тушаал / Мөрдөн байцаагч-ҮШ эмхтгэл. – УБ.: УМБГ. 2003. 78-81 дэх тал.
5. Сагсай.Ё “Мөрдөн байцаах ажлын чанар үр дүнг тодорхойлоход прокурорын хяналтын гүйцэтгэх үүрэг, үр нөлөө. УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл” Эх сурвалж, холбоос: <http://epmba.gov.mn>
6. МБГ-ын 2015-2016 оны үйл ажиллагааны статистик тайлан мэдээ.
7. Бямбадорж.Ж “Мөрдөн байцаалтын арга нь хэвээрээ байна” Эх сурвалж, холбоос: <http://mn-nhrc.org/index.php?newsid=5420>
8. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль: [2007 оны 8 дугаар сарын 9-ны өдөр УИХ-аас баталсан]. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=26835#>

